



2020 он

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

USAID BEST OYU
DEVELOPMENT
OYU TOLGOI YBM
SOLUTIONS
UNFPA KOICA THE ASIA FOUNDATION



Улаанбаатар хот, БЗД, 3-р хороо,
Энхтайвны өргөн чөлөө, 32-р байр, 19 тоот



7722-4001



info@dsmongolia.org



Хөгжлийн Шийдэл @dsmongolia



7722-2210



www.dsmongolia.org



Development Solutions NGO - Хөгжлийн Шийдэл ТББ

АГУУЛГА

1. Гүйцэтгэх захирлын мэндчилгээ
2. Удирдах зөвлөл
3. Хөгжлийн Шийдэл ТББ-ын хамт олон
4. Хөгжлийн Шийдэл ТББ-ын үйл ажиллагааны үндсэн үйлчилгээнүүд
5. Хөгжлийн Шийдэл ТББ-ын салбарууд
6. Үйл ажиллагааны үр дүн
7. Төсөл хөтөлбөрүүд
 - 🌀 BEST хөтөлбөр
 - 🌀 Өмнөговь аймгийн Эмэгтэйчүүд, залуусын эрүүл мэндийг дэмжих нэгдсэн хөтөлбөр
 - 🌀 Завхан аймгийн малчдын нийгмийн хамгаалыг өргөжүүлж, цочролд бэлэн байх чадавхыг нэмэгдүүлэх нь хөтөлбөр
 - 🌀 „Орон нутгийн хөдөө аж ахуйн бизнесийг дэмжих“ хөтөлбөр
 - 🌀 УВМ Залуусын Бизнесийг Дэмжих Санаачилга хөтөлбөр
 - 🌀 Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийн Төв төсөл

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт харилцагчид, түншүүд, удирдах зөвлөлийн гишүүд та бүхний амар мэндийг эрье.

Хөгжлийн Шийдэл ТББ нь шинэлэг, үр дүнтэй, шилдэг шийдлээр өрхийн амьдралын чанарыг сайжруулж, өсөлтөд чиглэсэн бизнесийн чадавхыг бий болгох зорилгоор 2008 онд байгуулагдаж байгаль орчинд ээлтэй нийгэм, эдийн засгийн өсөлтийг дэмжих эрхэм зорилготойгоор үйл ажиллагаагаа тогтвортой явуулсаар байна.

Дэлхий нийтийг хамарсан цар тахал бизнесийн бүхий л салбарт цоо шинэ хэв маягийг бий болгож эхэлсэн төдийгүй манай улсын жижиг, дунд бизнесүүдэд мөн адил хүндрэл учруулж, бизнесийн шинэ загварт шилжих зайлшгүй шаардлага бий болсныг харуулж байна. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд Хөгжлийн Шийдэл ТББ харилцагчдаа энэхүү шинэ хэв маягт шилжиж, дасан зохицоход нь цаг алдалгүй дэмжлэг үзүүлэн ажиллаа.

Үүний хүрээнд Монголын бизнесийн орчин нөхцөл, онцлог тохирсон олон улсын стандарт бүхий зөвлөх үйлчилгээг олон улсын болон дотоодын санхүүжүүлэгч байгууллагуудын дэмжлэгтэйгээр түншүүддээ хүргэж үйлчилсэн.

Бид Олон Улсын Чанарын Удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн Монголын анхны төрийн бус байгууллага төдийгүй Байгаль орчны менежментийн тогтолцооны ISO 14001:2015 стандарт болон ХАБЭА менежментийн тогтолцооны ISO 45001:2018 стандартуудыг тус тус нэвтрүүлэн ажиллаж эхэллээ.

2020 он хэдийгээр сорилт ихтэй жил байсан ч бид АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн (USAID)-ийн санхүүжилттэй „Бизнесийн Тогтвортой Хөгжлийг Сайжруулах, Ил Тод Байдлыг Нэмэгдүүлэх” таван жилийн хугацаатай „BEST” хөтөлбөрийг Улаанбаатар хот, 8 аймагт албан ёсоор хэрэгжүүлж байна. Мөн орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр Оюу толгой ХХК болон НҮБ-ын Хүн амын сангийн төслүүдтэй хамтран ажиллагаагаа өргөжүүлсэн.

Хөгжлийн Шийдэл ТББ 2020 оны байдлаар 4425 бизнесийг шинээр бий болж, 8217 бизнес өргөжихөд хувь нэмрээ оруулсан бөгөөд бидэнтэй хамтарч ажилладаг байгууллагуудын 60 хувь эмэгтэй бизнес эрхлэгч бол үлдсэн 40 хувь эрэгтэй бизнес эрхлэгчид байна.

Манай хамт олон Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй жижиг дунд бизнесүүдийг өргөжүүлэх, энтрепренер сэтгэлгээ болон соёлыг түгээх төсөл, хөтөлбөрүүдийг инновацлаг шийдлээр хэрэгжүүлэх үлгэр жишээ төрийн бус байгууллага байх зорилт тавин ажиллаж буй билээ.

Монголд жижиг дунд бизнес хөгжих экосистемийг бий болгохын төлөө хамтран ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагуудад Хөгжлийн Шийдэл ТББ-ын хамт олны зүгээс гүн талархал илэрхийлэе.

Ирэх он жилүүдэд та бидний харилцан итгэлцэл, хамтын ажиллагаа улам бүр өргөжин тэлж, өрнөн дэлгэрэх болтугай!

Хүндэтгэсэн: Гүйцэтгэх Захирал Б.ХИШИГСҮРЭН

УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Хөгжлийн Шийдэл ТББ-ын Удирдах Зөвлөл нь хууль эрх зүй, боловсрол, банк санхүү болон уул уурхайн салбарын төлөөлөл бүхий хараат бус 5 гишүүнээс бүрддэг. Удирдах Зөвлөл нь жилд дөрвөн удаагийн ээлжит хурлыг зохион байгуулж, стратегийн болон цаг үеийн зохих шийдвэрүүдийг гаргах үүрэг бүхий удирдах дээд байгууллага юм.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН



Лувсандоржийн
ОЮУН

МУИС-ийн БС-ийн Санхүүгийн
Хөтөлбөрийн багш, Профессор,
Удирдах зөвлөлийн дарга



Жигжидсүрэнгийн
ГАНТӨМӨР

ХААН Банкны Бизнесийн зээлийн эрсдэлийн
газрын Төслийн зээлийн Ахлах Менежер



Жуковын
БААТАРБОЛД

ХАС Банкны Салбарын Удирдлагын
хэлтсийн Захирал



Зоригийн
ТУЯА

New Urbanism ХХК-н
Захирал




Жамбалдоржийн
ЭРДЭНЭЧИМЭГ

Монголын эмэгтэйчүүдийн
холбооны ерөнхийлөгч асан

ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ ТББ ХАМТ ОЛОН

Хөгжлийн Шийдэл ТББ нийт 60 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж буй бөгөөд үүнээс 34 нь Улаанбаатар хотод ажиллаж байгаа бол үлдсэн ажилтнууд орон нутгийн 9 салбарт ажиллаж байна. Мөн 45 бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг ажилтнуудтай үйл ажиллагаа явуулж байна.

НИЙТ АЖИЛЛАХ ХҮЧИН:



(Ажилтнуудын дундаж нас: 35)



ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ ТББ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД



Бизнес хөгжил, сургалтын
үйлчилгээ



Бизнесийн зөвлөх
үйлчилгээ



Байгууллагын сургалтын
үйлчилгээ



Бизнес холболтын
үйлчилгээ



Олон нийтэд зориулсан
мэдээлийн үйлчилгээ



Санхүүгийн
үйлчилгээ



Бизнесийн бүлэг, хоршоо
хөгжүүлэх үйлчилгээ



ТББ-ыг чадавхжуулах
үйлчилгээ



Судалгаа хийх




Гарааны бизнесийн
хөтөлбөр




Менторинг

ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ ТББ-ЫН САЛБАРУУД



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН 2008-2020



ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД



АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн (USAID) санхүүжилтээр хэрэгжиж буй „Бизнесийн Тогтвортой Хөгжлийг Сайжруулах, Ил Тод Байдлыг Нэмэгдүүлэх (BEST) хөтөлбөр



НҮБ-ын Хүн Амын сантай хамтран хэрэгжүүлж буй Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих нэгдсэн хөтөлбөр, Завхан аймгийн малчдын нийгмийн хамгааллыг өргөжүүлж, цочролд бэлэн байх чадавхыг нэмэгдүүлэх нь хөтөлбөр



Оюу Толгой ХХК-ийн санхүүжилтээр хэрэгжиж буй „Орон Нутгийн Хөдөө Аж Ахуйн бизнесийг Дэмжих Хөтөлбөр”



Youth Business Mongolia – Залуусын Бизнесийг Дэмжих Санаачилга

БНСУ-ын Хамтын Ажиллагааны нийгэмлэг KOICA, Азийн Сан, Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газартай хамтран хэрэгжүүлж буй „Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийн Төв” төсөл

ЗОРИЛГО

Жижиг, дунд бизнесүүдийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлж, засаглал, ил тод байдлыг сайжруулах замаар Монгол улсын эдийн засгийг төрөлжүүлэх.

Өмнөговь аймгийн хэмжээнд болон Ханбогд сумын залуу малчид, залуусын нийгэмд ээлтэй, шинэлэг бизнес эрхлэх чадавхыг нэмэгдүүлэх.

Завхан аймгийн малчдын нийгмийн хамгааллыг өргөжүүлж, цочролд бэлэн байх чадавхыг нэмэгдүүлэх.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлээрээ бие даасан, өрсөлдөх чадвар бүхий бизнес, аж ахуйн нэгжүүдийг хөгжүүлэх замаар Ханбогд сумын эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

18-35 насны зорилтот бүлгийн залууст зориулан энтрепренершипийн цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

Улаанбаатар хотын эдийн засагт бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх.



 **USAID**
АМЕРИКИЙН АРА ТҮМНЭЭС

BEST
The Sustainability Impact

 **ХӨГЖЛИЙН ШАНТ**
ХАЙЛЖАА

BEST PR
SUSTAIN

BEST ХӨТӨЛБӨР

АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID) –ийн санхүүжилтээр Хөгжлийн Шийдэл ТББ нь „Бизнесийн Тогтвортой Хөгжлийг Сайжруулах, Ил Тод Байдлыг Нэмэгдүүлэх (BEST)” хөтөлбөр



Улаанбаатар хот болон Завхан, Орхон, Ховд, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Сэлэнгэ, Баянхонгор гэсэн 8 аймагт 2019 оны арванхоёрдугаар сараас эхэлсэн бол 2021 оны арванрхоёрдугаар сараас Өвөрхангай, Өмнөговь, Хэнтий, Хөвсгөл аймагт хэрэгжүүлнэ.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТУУД



ЖДБ-ийн санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлэх



ЖДБ-ийн засаглалыг сайжруулах



ЖДБ-ийн үйл ажиллагааг дэмждэг төрийн болон ТББ-уудын ил тод байдлыг хангах



Бизнесийн хөгжлийн стратегийг тодорхойлоход чиглэсэн судалгааг хийх



Цаашид тогтвортой хөгжих боломжтой, санхүүжилт авах чадамжгүй ТББ, ЖДБ гарааны бизнес болон эрхлэгчдэд бичил санхүүжилт олгох зэрэгт оршино.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Жижиг, дунд бизнесүүдийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлж, эдийн засгийн хариуцлага, ил тод байдлыг сайжруулах замаар Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэхэд чиглэнэ.





ACCOUNTABILITY
BANK
FAIRNESS
FINANCIAL PARTNERSHIP

ЗОРИЛТ - 1: ЖДБ-ИЙН САНХҮҮЖИЛТ АВАХ БОЛОМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

2020 он



Зуучилсан нийт зээлийн тоо, дүн

691 ЖДБ-д,
30.9 тэрбум ₮



Бизнесийн зөвлөх үйлчилгээ

948 ЖДБ-д



Бизнесийн сургалт

212, оролцогчид 3,284 ЖДБ



Мэдлэг хуваалцах уулзалт

127, уулзалтад оролцогчид
2,150 ЖДБ

СУРГАЛТЫН МОДУЛЬ





ЗОРИЛТ 2. ЖДБ-ИЙН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАХ


ЗОРИЛТ - 2: ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД






ЗОРИЛТ 3. ЖДБ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖДЭГ ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ

ЗОРИЛТ - 3:



ЗОРИЛТ 4. БИЗНЕСИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙГ ТОДОРХОЙЛОХОД ЧИГЛЭСЭН СУДАЛГАА ХИЙХ




КЛАСТЕРААР БҮСЧЛЭН
ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙГ
ТОГТООХ СУДАЛГАА.

КОВИД-19 ЦАР ТАХЛЫН
ЖДБ ЭРХЛЭГЧДЭД ҮЗҮҮЛЖ БҮЙ
НӨЛӨӨЛЛИЙН СУДАЛГАА

“ЖИЖИГ, ДУНД БИЗНЕСИЙН
САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ
БАЙДАЛ”

“Энэхүү судалгааг АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID)-аар дамжуулан Америкийн ард түмний өгөөмөр дэмжлэгтэйгээр боловсруулсан болно. Хөгжлийн Шийдэл ТББ нь судалгаатай холбоотой хариуцлагыг бүрэн хүлээх бөгөөд үүнд АНУ-ын Засгийн Газар болон АНУ-ын USAID-ийн үзэл бодлыг илэрхийлээгүй болно.”

ЗОРИЛТ - 4: БИЗНЕСИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙГ ТОДОРХОЙЛОХОД ЧИГЛЭСЭН СУДАЛГАА ХИЙХ





ЗОРИЛТ - 5: БИЧИЛ САНХҮҮЖИЛТИЙН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

ЗОРИЛТ - 5: ХУРДАСГУУР ХӨТӨЛБӨР

Цаашид тогтвортой хөгжих хэдий ч зээл, санхүүжилт авах боломжгүй орон нутгийн ЖДБ, гарааны бизнес эрхлэгчид

ХӨТӨЛБӨРТ ХЭН
ХАМРАГДАХ
БОЛОМЖТОЙ ВЭ?

ЖДБ-ийг дэмжих зорилго бүхий төрийн сангуудыг ил тод, нээлтэй болгоход чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг орон нутгийн ТББ-д хамрагдах боломжтой

НЭГ БАЙГУУЛЛАГАД ОЛГОГДОХ ТЭТГЭЛГИЙН ХЭМЖЭЭ:

10,000,000₮ ХҮРТЭЛ

Хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан чадавхжуулах ХУРДАСГУУР ХӨТӨЛБӨРИЙН сургалт зөвлөх үйлчилгээнд

27

Ховд аймгаас нийт хамрагдсан горилогчид

17

Баянхонгор аймгаас нийт хамрагдсан горилогчид

BEST ХӨТӨЛБӨРИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



БИЗНЕСИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ САЙЖРУУЛАХ, ИЛ ТОД БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ (BEST) ХӨТӨЛБӨР,, COVID-19: ТҮНШЛЭЛИЙН ХҮРЭЭНД ЖИЖИГ, ДУНД БИЗНЕСҮҮДИЙН САНХҮҮЖИЛТИЙГ ДЭМЖИХ НЬ ФОРУМ - 2021” ФОРУМЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ.

Хөгжлийн Шийдэл ТББ нь BEST хөтөлбөрийн хүрээнд „COVID-19: Түншлэлийн хүрээнд жижиг, дунд бизнесүүдийн санхүүжилтийг дэмжих форум-2021”-ыг зохион байгуулсан. Тус форумын зорилго нь коронавирус цар тахлын үед ЖДБ-үүдэд тулгарч буй санхүүжилтийн бэрхшээлийг оролцогч талуудын хамтын ажиллагааг сайжруулах замаар шийдэх боломжийн тухай нээлттэй хэлэлцүүлгийг явуулсан.

Тус арга хэмжээнд АНУ-ын Элчин сайдын яам, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яам, Авлигатай тэмцэх газар, АНУ-ын Худалдааны танхим, төрийн болон хувийн хэвшлийн холбогдох төлөөлөгчид оролцлоо.

Цар тахлын үед оролцогчдод биечлэн эсхүл цахим шугамаар оролцох боломжийг бий болгосон бөгөөд нийт 100 гаруй төлөөлөгчид биечлэн оролцож, хөтөлбөр хэрэгжүүлж буй 8 аймаг (Баянхонгор, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Ховд, Орхон, Сэлэнгэ, Завхан)-т 200 гаруй төлөөлөгч цахимаар хамрагдсан.

Форумыг ЖДБ-ийг дэмжих чиглэлээр төрөөс баримтлах бодлого, чиглэл, хамтын ажиллагаа болон Төрийн бус байгууллага, судлаачдын зүгээс ЖДБ-үүдэд үүсэж буй нөхцөл байдал, цаашдын хандлага, олон улсад хэрэгжүүлж буй туршлага, зөвлөмжүүд гэсэн хоёр хэсэгт хуваан зохион байгуулсан бөгөөд төрийн болон хувийн хэвшлийн салбарын төлөөлөл хоорондын нээлттэй хэлэлцүүлэг хийх, боломжит шийдлүүдийн талаар санал солилцсон үр дүнтэй арга хэмжээ болсон.

АМЖИЛТЫН ТҮҮХ

Бизнес эрхлэгч Ж.Сарнай: “BEST хөтөлбөрт хамрагдсан туршлага надад хайрцгаас гарч сэтгэхийн жинхэнэ утга учрыг мэдрүүлсэн. Зөв цагтаа зөв шийдлийг хэрэгжүүлж чадсан тул бизнесээ эрсдэлээс аварсан.”



Баянхонгор аймгийн бизнес эрхлэгч Ж.Сарнай спорт хувцасны үйлдвэрлэлийн чиглэлээр дагнасан оёдлын компаниа 2014 онд байгуулсан байна.

Тэрээр жижиг дунд бизнесүүдийн жишгээр Ж.Сарнай олон жилийн турш уналт, босолттой тулгарсан ч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулсны эцэст 2020 он гэхэд түүний спортын хувцасны брэнд зах зээлд хэдийн танигдаж, өөрийн байр сууриа олжээ.



Харин Засгийн газар коронавирусын тархалтаас сэргийлэхээр орон даяар бүх шатны сургуулиудыг хаах шийдвэр гаргасан нь түүний бизнест томоохон эрсдэлийг авчирчээ. Энэ үеэр „Бизнесээ цаашид хэрхэн хэвийн үргэлжлүүлэх вэ, ажилтнуудынхаа ажлын байрыг хэрхэн хадгалж үлдэх вэ?“ зэрэг асуултаудтай тулгарч эхэлсэн байна. „Энэ олон жилийн дараа би бизнесээ эхлүүлсэн цэг дээрээ буцаж ирж нөхцөл байдлаас хэрхэн хохирол багатай гарах талаар ихэд санаа зовниж байв.



Асуудал нь өөрөө шийдлийг агуулдаг гэдэгт итгэж ирсэн ч үнэн хэрэгтээ энэ сорилтыг хэрхэн даван туулахаа учраа сайн мэдэхгүй байсан.” гэж Ж.Сарнай хэлж байсан юм.

Бизнесийнх нь үйл ажиллагаа удааширсан тухайн үед өөрийгөө хөгжүүлж, эрсдэлээс гарах арга зам хайж, Хөгжлийн Шийдэл ТББ-ын хэрэгжүүлж буй USAID-ийн BEST хөтөлбөрийн цахим сургалтад хамрагдахаар шийджээ.

Сургалтад хамрагдсанаар үүссэн бүх бэрхшээлийг боломж болгон харж эхэлснээр түүнд найдлага төрж, сургалтаар олж авсан мэдлэгээ бизнестээ хэрэгжүүлэхээр BEST хөтөлбөрийн бизнесийн зөвлөхөөс техникийн туслалцаа авчээ.

Тэрээр бизнесээ шинэ хэвийн байдалд уялдуулах ганцаарчилсан зөвлөгөөнд хамрагдаж, бизнесийн загвараа өөрчлөхөөр дараах шийдлүүдийг хэрэгжүүлсэн байна.



Тодруулбал, Ж.Сарнай үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийхээ нэр төрлийг амны хаалт, хамгааллын хэрэгсэл зэргээр олшруулсан төдийгүй бүтээгдэхүүнүүдээ эмийн сан болон хүнсний дэлгүүрийн бараагаар бартер хийж, нэг удаагийн амны хаалт, ариутгагч бодис болон хүнсний бүтээгдэхүүнүүд авчээ.

Тэрээр солилцооны бараагаа хөл хорионы үеэр ажилтнууддаа урамшуулал болгон өгдөг байсан төдийгүй ажилтнуудынхаа гэр бүлд өөрийн бүтээгдэхүүний эрхийн бичгийг хүртэл олгосог байна.

Ж.Сарнай хөтөлбөрт хамрагдсан сэтгэгдлээ ийн хуваалцсан юм.

„USAID-ийн BEST хөтөлбөрт хамрагдсан туршлага надад хайрцгаас гарч сэтгэхийн жинхэнэ утга учрыг мэдрүүлсэн гэж хэлж болно. Зөв цагтаа зөв шийдлийг хэрэгжүүлж чадсан тул бизнесээ эрсдэлээс аварсан. Хүний нөөцийн тогтвортой байдал нь аливаа бизнес үйл ажиллагаагаа амжилттай явуулахад чухал хүчин зүйлсийн нэг байдаг.




Эдийн засгийн хүндрэлийн үед ажилтнууддаа цомхтогхын оронд энэ мэт урамшуулмыг санал болгосон нь тэднийг өндөр бүтээмжтэй, хоёргүй сэтгэлээр ажиллах хөшүүрэг, сэдэл болсон. Цаашид энэ хөтөлбөрийн нэг эд эс байж, хамтран ажиллахдаа үргэлж сэтгэл хангалуун байх болно.”



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЭМЭГТЭЙЧҮҮД, ЗАЛУУЧУУДЫН ЭРҮҮЛ МЭНДИЙГ
ДЭМЖИХ НЭГДСЭН ХӨТӨЛБӨР

Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуусын эрүүл мэндийг дэмжих нэгдсэн хөтөлбөрийн хүрээнд залуус өсвөр насныхны оролцоог нэмэгдүүлэхийн тулд Залуучуудын гарааны бизнес, залуу малчдын хоршоодыг дэмжсэн байх гэсэн зорилтыг хэрэгжүүлэхээр НҮБ-ын Хүн Амын сан, „Говийн Оюу” хөгжлийг дэмжих сангийн санхүүжилтээр Өмнөговь аймагт хэрэгжиж байна.



ХӨТӨЛБӨРИЙН ҮЕ ШАТУУД

1

ГАРААНЫ БИЗНЕСИЙН ШАЛГАРУУЛАЛТ

2020 оны 9-р сарын 17-оос 19-ны хооронд Даланзадгад суманд явагдаж 29 багийн 62 залуус оролцсон.

2

ХҮРДАСГУУР СУРГАЛТ

12 багийн нийт 20 оролцогчтой Бүтээгдэхүүн хөгжүүлэлт, Борлуулалтын менежмент, Сошиал медиа, Эрсдэлийн менежментийн сургалтыг 2020 оны 10-р сарын 28-аас 29-ны хооронд зохион байгуулаа.

3

ЦАХИМ ХҮРДАСГУУРЫН СУРГАЛТ

"Сав баглаа боодол, Бизнес холболт ба маркетинг, Брэнд бүтээх сэдвүүдээр сургалт заасан.



ХӨТӨЛБӨРИЙН ҮЕ ШАТУУД

4

ЦАХИМ ФОРУМ

2020 оны арванхоёрдугаар сард Хөгжлийн Шийдэл ТББ нь НҮБ-ын Хүн амын сан, Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар зэрэг байгууллагуудтай хамтран „Говийн залуус- Нийгмийн энтрепренершип“ цахим форумыг тус аймгийн шинэлэг бизнес эхлүүлэх хүсэлтэй залууст зориулан зохион байгуулсан.

Форумаар Өмнөговь аймгийн бодлогын орчин, бизнесийн санхүүжилтийн хүртээмж, зах зээл, энтрепренершип соёл, хүний нөөц зэрэг 11 сэдвийн хүрээнд илтгэл зохион байгуулж 287 хүнийг хамруулсан. Мөн үеэр Даланзадгадаас шалгарсан 12 гарааны бизнесийг сурталчлан танилцуулсан нь гарааны бизнес эхлүүлэх хүсэл эрмэлзэлтэй залууст хөшүүрэг болох үр дүнтэй ажил болсон.

5

САНХҮҮЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ ХУДАЛДАН АВАЛТ

Төсөлд шалгарсан 12 багийн гарааны бизнест 35 сая 720 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.






ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЭМЭГТЭЙЧҮҮД, ЗАЛУУЧУУДЫН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ
НЭГДСЭН ХӨТӨЛБӨР- ХАНБОГД СУМ



Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуусын эрүүл мэндийг дэмжих нэгдсэн хөтөлбөрийн хүрээнд залуус өсвөр насныхны оролцоог нэмэгдүүлэхийн тулд Залуучуудын гарааны бизнес, залуу малчдын хоршоодыг дэмжсэн байх гэсэн зорилтыг хэрэгжүүлэхээр НҮБ-ийн Хүн Амын сан, Оюу Толгой ХХК-ийн санхүүжилтээр Өмнөговь аймгийн Ханбогд суманд хэрэгжиж байна.



ХӨТӨЛБӨРИЙН ҮЕ ШАТУУД

1

ГАРААНЫ БИЗНЕСИЙН ШАЛГАРУУЛАЛТ

2020 оны 6-р сард Ханбогд суманд шалгаруулалт явагдаж 22 багийн 72 залуус оролцсон.

2

ХУРДАСГУУР СУРГАЛТ

Хурдасгуур сургалтад шалгарсан 8 багийн 32 гишүүнийг чадавхжуулахаар 2 удаагийн танхимын сургалт, 5 удаагийн цахим сургалт зохион байгуулаа.

3

САНХҮҮЖИЛТЭЙ ХОЛБООТОЙ ХУДАЛДАН АВАЛТ

Шалгарсан 8 багт бизнесээ эхлүүлэх, өргөжүүлэхэд нийт 25 сая 800 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.






ЗАВХАН АЙМГИЙН МАЛЧДЫН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ ӨРГӨЖҮҮЛЖ, ЦОЧРОЛД БЭЛЭН БАЙХ ЧАДАВХЫГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ ХӨТӨЛБӨР



НҮБ-ын Хүн Амын сан, JOINT SDG FUND-ийн санхүүжилтээр Хөгжлийн Шийдэл ТББ-ын хэрэгжүүлж буй „Завхан аймгийн малчдын нийгмийн хамгаалмыг өргөжүүлж, цочролд бэлэн байх чадварыг нэмэгдүүлэх нь хөтөлбөр”-ийн хүрээнд малчдын нийгэмд ээлтэй бизнес эрхлэлтийг дэмжиж байна.



ХӨТӨЛБӨРИЙН ҮЕ ШАТУУД

1

ГАРААНЫ БИЗНЕСИЙН ШАЛГАРУУЛАЛТ

Хөтөлбөрийн хүрээнд 2020 оны 6-р сард бизнес санааны сургалтууд, 8-р сард төсөл боловсруулах сургалтуудыг тус тус зохион байгуулсан. Тус хөтөлбөрт таван сумын 150 малчин хамрагдаж 36 төслийг санаа гарснаас 103 малчдыг хамруулсан/Эрэгтэй-49, Эмэгтэй-54/ 13 төсөл шалгарсан.

2

САНХҮҮЖИЛТ ОЛГОХ, ХУДАЛДАН АВАЛТ

Шалгарсан 13 багт 138,458,300 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.






„ОРОН НУТГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ“ ХӨТӨЛБӨР

Хөгжлийн Шийдэл ТББ нь Өмнөговь аймгийн Ханбогд суманд Оюу Толгой ХХК-ийн хэрэгжүүлж буй Орон Нутгийн Хөдөө Аж Ахуйн Бизнесийг Дэмжих Хөтөлбөрт 2019 оноос эхлэн хоёр дахь жилдээ зөвлөх үйлчилгээ үзүүлж байна.

Тус хөтөлбөрийн зорилго нь Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр өрсөлдөх чадвар бүхий бие даасан аж ахуйн нэгжүүдийг хөгжүүлэх замаар Ханбогд сумын эдийн засгийг төрөлжүүлэн, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм.



2020 оны байдлаар тус хөтөлбөрийн хүрээнд нийт



„Орон Нутгийн Хөдөө Аж Ахуйн Бизнесийг Дэмжих хөтөлбөр“-ийн харилцагчдын стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө, шинээр байгуулагдаж буй хоршоодын дүрэм, журам болон гомдол барагдуулах гэрээний дагуу хэрэгжих томоохон төслүүдийн засаглалын хувилбаруудыг боловсруулахад судалгаа, үнэлгээний ажлуудыг гүйцэтгэсэн.



ЗАЛУУСЫН БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ САНААЧИЛГА ХӨТӨЛБӨР

Залуусын Бизнесийг Дэмжих Санаачилга хөтөлбөр нь 18-35 насны зорилтот бүлгийн залууст зориулсан энтрепренершипийн цогц хөтөлбөрийг бий болгож бизнесээ эхлэх, хөгжүүлэхэд шаардлагатай үр чадварыг олгоход дэмжлэг үзүүлэх зорилготой.

ҮБТ буюу Залуусын Бизнесийг Дэмжих Санаачлага нь дэлхийн 50 гаруй оронд гишүүнчлэлтэй, залууст чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг, ашгийн бус олон улсын байгууллага юм.

Анх ИБУИНВУ-ын Уэльсийн хунтайж Чарльзийн санаачлагаар залуусын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр мониторинг, санхүүжилт болон энтрепренерийн сургалтуудыг зохион байгуулж эхэлсэн бөгөөд 2025 он гэхэд дэлхий даяар 1 сая залуусыг ажлын байртай болгох зорилготой.

„Хөгжлийн Шийдэл“ ТББ нь тус санаачлагыг Монголд хэрэгжүүлэгч итгэмжлэгдсэн байгууллагаар 2013 оноос хойш ажиллаж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН - 2020 он



2726

ЗАЛУУ ЭНТЕРПРЕНЕР
ХАРИЛЦАГЧ



42

ШИНЭ БИЗНЕС



407

ӨРГӨЖИН САЙЖИРСАН
БИЗНЕС



290

ШИНЭЭР БИЙ БОЛСОН
АЖЛЫН БАЙР



1910

ХҮНД СУРГАЛТ,
ЗӨВЛӨГӨӨ ҮЗҮҮЛСЭН



308

МЕНТОРИНГ ҮЙЛЧИЛГЭЭ
ҮЗҮҮЛСЭН



254

АМЖИЛТАЙ ЗЭЭЛИЙН
ЗУУЧЛАЛ



БИЗНЕС ЭРХЛЭГЧ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТӨВ ТӨСӨЛ

ТОВЧТАНИЛЦУУЛГА:

Хөгжлийн Шийдэл ТББ нь „Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийн Төв” төслийг БНСУ-ын Хамтын ажиллагааны нийгэмлэг- KOICA ОУ-ын байгууллагын санхүүжилтэйгээр Азийн сан, НЗДТГ, Солютек Систем ХХК, МҮХАҮТ, Голомт банктай хамтран 2016-2020 оны хугацаанд хэрэгжүүлсэн. Тус төслийн үндсэн үйл ажиллагаа болон хурдавчилсан инкубаторын хөтөлбөрийг Хөгжлийн Шийдэл ТББ хариуцан амжилттай хэрэгжүүллээ.

ЗОРИЛГО:

“Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийн Төв төсөл” нь Улаанбаатар хотын эдийн засагт бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилготой.



(Борлуулалтын орлого олоход дэмжлэг үзүүлсэн)



ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГУУД



USAID



Хүнс, Хөдөө Аж Ахуй
Хөнгөн Үйлдвэрийн яам



Жижиг дунд
үйлдвэрийн газар



НЗДТГ



Хөдөлмөр Халамж
Үйлчилгээний Ерөнхий
Газар



Зээлийн батлан
даалтын сан



НҮБ-ын Хүн
Амын сан



Оюу Толгой



YBI



KOICA



The Asia
Foundation



МҮХАҮТ



Монголын
Бизнес Зөвлөл



Хуульчдын
холбоо



MMCI



Банк Санхүүгийн
Академи



AMCHAM



American
Management
Association



Герман Монголын
Бизнес Эрхлэгчдийн
Холбоо



Худалдаа
хөгжлийн банк



Голомт банк



Хаан банк



Хас банк



Төрийн банк



Кредит банк



Капитрон банк



Транс банк



Ард кредит
ББСБ



Транскапитал
ББСБ



Жи Эс Би
капитал ББСБ